

Ээлжит хичээлийн хөтөлбөр-2

Хамрах хүрээ: 6-р анги

Сэдэв: Тэнхлэгийн тэгш хэм

Хугацаа: 40 минут

Зорилго: Дүрсийн тэнхлэгийн тэгш хэмийн хувиргалтын шинж чанарыг мэдэх



Зорилт:


- Цэгийг шулууны хувьд тэгш хэмтэй хувиргах
- Хэрчмийг шулууны хувьд тэгш хэмтэй хувиргах
- Дүрсийн тэгш хэмийн тэнхлэгийг тодорхойлож, тэнхлэгийн тэгш хэмээр хувиргах

Агуулга:

Өмнө судалсан агуулга	Цаашид судлах агуулга
- Тэгш хэмтэй дүрсийг таних, тэгш хэмийн тэнхлэгийг тодорхойлох, тэгш хэмтэй дүрс, тэгш хэмийн тэнхлэгийг зурах; эдгээртэй холбогдох агуулгатай асуудал шийдвэрлэх	- Дүрсийн тэгш хэмт чанарыг тогтоох, тэнхлэгийн тэгш хэмээр дараалан хувиргах

Цагийн төлөвлөлт:

Хичээлийн бүтцийн явц	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа
Хичээл зохион байгуулалт - 1 минут	- Сурагчидтай мэндлэнэ - Хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэнэ.	- Багштай мэндлэнэ - Сурагчид хичээлийн бэлтгэл байдлыг хангана.
(Сэдэлжүүлэлт) - 5 минут	Алхам 1 Шинж чанараараа ижил зургийг ангилна уу? Ямар зүй тогтоолоор зургийг ангилсан бэ? Алхам 2 Зургуудын ижил болон ялгаатай шинж нь юу вэ? Эдгээр нь тэгш хэмийн тэнхлэгтэй юу? Аль нь хэдэн тэгш хэмийн тэнхлэгтэй байна вэ? <ul style="list-style-type: none"> • Тэгш хэмтэй дүрс • Тэгш хэмгүй дүрс гэж ангилна. 	<ul style="list-style-type: none"> • Дүрс ижил хэсгүүдэд хуваагдаж байна • Нугалахад ижил зургууд гарч байна гэх мэт 
Шинэ хичээл - 15 минут	Асуулт А A_1 цэгийн координат өгөгдсөн бол 2 цэгийг холбосон хэрчмийг хагаслан хуваах цэгийн координатыг олно уу? A(1,1) B(5,5) Хэрэв А В хэрчим С цэгээр хагаслан хуваагдаж байвал ($AC=CB$) эдгээр цэгүүдийг О цэгийн хувьд тэгш хэмтэй гэнэ.	

<p>Бататгах - 10 минут</p>	<p>Өгөгдсөн зургууд дээр дүн шинжилгээ хийж тайлбарлацгаая</p> <ul style="list-style-type: none"> Алхам 2 <p>Цаасан дээрх дүрсүүдийг өгөгдсөн цэгүүд өөр дээрээ байрлахаар нугалаарай.</p> <p>Даалгаврын зорилго: (Дүрсийн тэгш хэмт чанарыг ялгаж тодорхойлох, тайлбарлах)</p> <p>Алхам 3</p> <p>Цаасаа эргэн дэлгэж нуглаасанд үүссэн шулууныг тодруулаарай.</p> <p>Асуулт</p> <p>Энэ шулуунаар дүрс хэрхэн хуваагдаж байна вэ? (Шулууныг тэгш хэмийн тэнхлэг гэнэ)</p> <p>Даалгаврын зорилго: дүрсийн тэгш хэмийн тэнхлэгийг таних, зурах</p> <p>Алхам 4</p> <p>Зургийг ажиглан сүүлчийн зургийг гүйцээж зураарай.</p> <p>дгээр хувиргалтуудыг тэгш хэмийн хувиргалт гэнэ. Өгсөн дүрстэй тэгш хэмтэй дүрсийг зураарай.</p>	
<p>Үнэлгээ - 5 минут</p>	<p>Дүрсийг хэрхэн зөв хувиргасан байдлыг үнэлнэ.</p> <p>Цэг, хэрчмийг тэгш хэмээр хувиргах арга барил эзэмшсэн сурагч дүрсийг хувиргаж чадна. Өгсөн дүрсийн оройн цэгүүдээс шулуунд перпендикуляр татаад шулууны нөгөө талд ижил зайд тэмдэглэгдсэн цэг оройн цэгтэй уг шулууны хувьд тэгш хэмтэй байж чадах уу? гэдгийг ойлгуулах нь чухал.</p> <p>Өгсөн дүрсүүдийг өгсөн шулуун болон координатын тэнхлэгүүдийн хувьд тэгш хэмтэй байгуулах чадвар эзэмшинэ.</p>	
<p>Дүгнэлт - 2 мин</p>	<p>Тэгш хэмийн хувиргалтын шинж чанарыг хамтдаа тодорхойлцгооё</p> <p>Асуулт</p> <p>Тэгш хэмийн хувиргалтаар дүрс ямар дүрсэд шилжиж байна вэ? (Тэгш хэмийн хувиргалтаар дүрсүүд тэнцүү дүрсэд шилждэг болохыг мэдэх)</p> <p>Даалгаврын зорилго: Дүрсийн тэгш хэмт чанарыг ялгаж тодорхойлох, тайлбарлах;</p>	
<p>Гэрийн даалгавар - 2 минут</p>	<p>Сурах бичгийн хуудас дасгал бодлогыг бодох</p>	